



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/192

Чингис хот

Ч.Чинбатад буцалтгүй тусламж олгох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэрх хотын захирагч Чадраабалын Чинбатын гэр бүлийн хүн гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай болсон тул 1000000 /нэг сая/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид зарцуулах 1000000 /нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА